



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.11.01 № 7/1603
танай 2024.10.22 -ны № 4/1932 -Т

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА Г.ЧИНЗОРИГ ТАНАА

“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд өөрчлөлт оруулах тухай” Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 203 дугаар тогтоолыг үндэслэн захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6120 дугаарт бүртгэлтэй “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-г шинэчлэн батлах тухай Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 61 дүгээр тогтоолын хавсралтад оруулсан өөрчлөлтийг хүлээн авч, санд холбогдох хөдөлгөөн хийснийг үүгээр мэдэгдье.



О.АЛТАНГЭРЭЛ

15160/251
Аб.байл, 2024



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

Захирагчийн тогтоолын
актын улсын нөхцөл байдлыг
лолчоны 11. сарын 01-ний
өдөр хүлээн авч үзсэн.

2024 оны 10 сарын 15 өдөр

Дугаар 203

Улаанбаатар хот

“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-нд
өөрчлөлт оруулах тухай







Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.11 дэх заалт, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2017 оны А/42 тоот тушаалын хавсралтаар баталсан “Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох журам”-ыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны 61 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Хүснэгт-1. Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-ний 1, 4, 5, 6, 9, 12 дахь хэсэгт дараах өөрчлөлтийг оруулсугай.

- 1.1. 1.Арилжааны радио, телевизийн үйлчилгээ эрхлэх, Арилжааны телевиз, Монгол Улсын нутаг дэвсгэрт “4,500.0” гэснийг “7,700.0” гэж, Улаанбаатарт “2,500.0” гэснийг “4,000.0” гэж, Аймагт “600.0” гэснийг “750,0” гэж,
- 1.2. 4.Олон нийтийн радио, телевизийн үйлчилгээ эрхлэх, Олон нийтийн телевиз “3,000.0” гэснийг “7,900.0” гэж, олон нийтийн радио “1,500.0” гэснийг “3,900.0” гэж,
- 1.3. 5.Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх, Утастай, утасгүй сүлжээгээр олон суваг дамжуулах үйлчилгээ, Монгол Улсын нутаг дэвсгэрт “8,000.0” гэснийг “14,900.0” гэж, Улаанбаатарт “3,500.0” гэснийг “5,500.0” гэж, Аймагт “800.0” гэснийг “1,200.0” гэж,
- 1.4. 6.Өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн үйлчилгээ эрхлэх, Өргөн нэвтрүүлгийн телевиз, Монгол Улсын нутаг дэвсгэрт “6,000.0” гэснийг “12,900.0” гэж, Улаанбаатарт “3,000.0” гэснийг “4,300.0” гэж, Аймагт “800.0” гэснийг “1,000.0” гэж, Өргөн нэвтрүүлгийн радио Монгол Улсын нутаг дэвсгэрт “2,500.0” гэснийг “3,900.0” гэж, Улаанбаатарт “800.0” гэснийг “1,400.0” гэж, Аймагт “200.0” гэснийг “300.0” гэж,
- 1.5. 9.Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүнийг ашиглалт үйлчилгээ эрхлэх, Хот, хот хоорондын сүлжээ “15,000.0” гэснийг “39,600.0” гэж, Шуудангийн сүлжээ “3,000.0” гэснийг “25,100.0” гэж,
- 1.6. 12.Төлбөртэй радио, телевизийн үйлчилгээ эрхлэх, Төлбөртэй телевиз “5,000.0” гэснийг “7,700.0” гэж, Төлбөртэй радио “2,500.0” гэснийг “3,900.0” гэж тус тус өөрчлөх.

Хоёр. Энэхүү тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

Гурав. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг /-т үүрэг болгосугай.

ДАРГА		Г.ЧИНЗОРИГ
ГИШҮҮД		Б.АНХБААТАР
		Б.БАТЗОРИГ
		Ч.ЗОЛБАЯР
		А.ЛУВСАН-ОЧИР
		Н.МАНДАХБААТАР
		А.ҮЙЛСТӨГӨЛДӨР